

Чимэгэ бичээч системийг нэвтрүүлэхийн өмнөх нөхцөл байдлыг тодорхойлох судалгаа



Ажлын хэсэг
Улаанбаатар хот
2023 он



АГУУЛГА

ГРАФИК, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ 2

ОРШИЛ 3

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ 3

**СУДАЛГААНД ОРОЛЦСОН ШҮҮХ ХУРАЛДААНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
НАРЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ 5**

ШХНБД НАРЫН УР ЧАДВАРЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ: 7

**ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХУУЛИЙН ХУГАЦААНД
БАТАЛГААЖУУЛАХАД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ:
..... 8**

ЧИМЭГЭ БИЧЭЭЧ СИСТЕМИЙГ АШИГЛАЛТЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ 21

ДҮГНЭЛТ..... 26

ХАВСРАЛТ 30





ГРАФИК, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ГРАФИК:

График 1. Анхан болон давж заалдах шатны шүүхэд ажиллаж буй ШХНБД (Давхардсан тоогоор)	5
График 2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрөл /Давхардсан тоогоор/	5
График 3. Хоёроос дөрвөн төрлийн ажиллагаанд оролцох буй байдал (Давхардсан тоогоор).....	5
График 4. Шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалд ажилласан хугацаа.....	6
График 5. ШХНБД-ын 1 минутад бичих тэмдэгтийн хурд	7
График 6. Нэг цаг үргэлжилсэн шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөхөд зарцуулж буй хугацаа: <i>Графикт оролцогчдын тоогоор харуулав.</i>	8
График 7. ШХНБД нарын хугацаа хэтрүүлж буй байдлыг ажилласан жилээр нь харуулбал:	10
График 8. ШХНБД нарын хугацаа хэтрүүлж буй байдлыг шүүхийн байршлаар нь харуулбал:	10
График 9. Хугацаа хэтрүүлж буй байдлыг албан тушаалтан бүрийн үнэлгээгээр харуулбал:	10
График 10. Шүүх хуралдааны тэмдэглэлийг хуульд заасан хугацааг хэтрүүлж албажуулж буй шалтгаан нөхцөл. /Оролцогчийн хувь, тоог давтамгдсан утгаар/	11
График 11. Шүүх хуралдааны тэмдэглэлийг хуульд заасан хугацааг хэтрүүлж албажуулж буй шалтгаан нөхцөл	13
График 12. Тэмдэглэлийг хуулийн хугацаа хэтрүүлж албажуулж буй хугацаа:	15
График 13. Найруулга зүй хийх ур чадвар	15
График 14. Шивэх чадвар (нэг минутад)	16
График 15. Шүүх хуралдааны тэмдэглэлийг шүүгчийн туслах болон шүүгчээр хянуулахад зарцуулагдаж буй хугацаа:	16
График 16. ШХНБД нарын найруулга зүй хийх ур чадвар болон шивэх хурд	19
График 17. Авиаг бичвэр болгон хувиргадаг “Чимэгэ бичээч систем”-ийг ашиглаж байсан эсэх:	21
График 18. “Чимэгэ бичээч систем”-ийг ашиглахад хүндрэл гардаг эсэх:	21
График 19. Чимэгэ бичээч системийн хувилбарын ашиглалт	22
График 20. Чимэгэ бичээч систем ашиглалтын хугацаа, давтамж	22
График 21. Чимэгэ бичээч систем нь дараах боломжуудтай бөгөөд ашиглах явцад тус боломжууд хэр боломжийн байсан эсэхийг үнэлүүлэхэд:	22
График 22. “Чимэгэ бичээч систем”-ийг ашигласнаар шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөх ажилд үзүүлсэн нөлөөлөл.	24
График 23. Чимэгэ бичээч системийг ашиглахад нөлөөлөх хүчин зүйлсийг харуулав.	24
График 24. “Чимэгэ бичээч систем”-ийг шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөхөд хэр боломжийн гэж үзэж байна вэ?.....	25
График 25. Системийг ашиглаж байсан оролцогчдын хувьд “Чимэгэ бичээч систем”-ийг шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөхөд хэр боломжийн эсэхийг тодруулж асуухад:	25

ХҮСНЭГТ:

Хүснэгт 1. Ажлын 5 хоногт оролцож байгаа шүүх хуралдааны дундаж тоо:	7
Хүснэгт 2. Өдөрт оролцож байгаа шүүх хуралдаан /оролцогчдын тоогоор/	7
Хүснэгт 3. 1 цаг үргэлжилсэн шүүх хуралдааны тэмдэглэлийг “Чимэгэ бичээч систем” систем ашиглан хөрвүүлэхэд хэдэн минут зарцуулдаг болон системээр хөрвүүлсэн 1 цагийн шүүх хуралдааны тэмдэглэлийн агуулга, найруулга засах, хэлбэрт оруулахад зарцуулдаг хугацааг харуулав.	23



ОРШИЛ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2020 оны 04 дүгээр тогтоолоор баталсан Шүүхийн захиргааны байгууллагын стратеги төлөвлөгөөний “Шүүхийн тогтолцоо, хэрэг хянан шийдвэрлэх ажиллаг бүтээмжтэй болгоно” гэсэн 3 дахь зорилтын “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүтээмжийг дээшлүүлэх” 3.2-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээний 6-д “шүүх хуралдааны тэмдэглэлийг хөтлөхөд авиаг бичвэрт хувиргах төхөөрөмжийг нэвтрүүлэх”-р тусгасан.

Түүнчлэн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасны дагуу “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан Ерөнхий зөвлөлийн 2022 оны 332 дугаар тогтоолоор “Шүүхэд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлого”-ын баримт бичгийг баталж, шүүхийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи, инновацыг ашиглан шүүх, шүүхийн захиргааны үйл ажиллагааны цахим шилжилтийн түвшнийг тогтмол нэмэгдүүлэх зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Мөн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсэгт “Шүүх хуралдааны тэмдэглэлийг мэдээллийн технологи ашиглан хөтөлж болно.” гэж заасан.

- **Судалгааны зорилго:**

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2023 оны А/70 дугаар тушаалаар шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөх үйл ажиллагааг цахимжуулах, авиаг бичвэрт хөрвүүлэх систем ашиглах хэрэгцээ шаардлага үүссэн эсэх асуудлыг тодорхойлох зорилгоор дараах 3 төрлийн багц судалгааг хийж, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулж, бүрэлдэхүүнийг баталсан. Үүнд:

Судалгаа №01: “Чимэгэ системийг нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага үүссэн эсэх тандах судалгаа”;

Судалгаа №02: “Чимэгэ систем ашиглалтын явц дахь мониторингийн судалгаа”;

Судалгаа №03: “Чимэгэ систем хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа”.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Ажлын хэсэг судалгааг хийхдээ судалгааны объект буюу оролцогчдыг хамруулсан социологийн асуулга, анкетын аргаар мэдээлэл цуглуулж, түүнд дүн шинжилгээ хийх, холбогдох нэгжээс статистик мэдээлэл гаргуулан авах, оролцогчидтой ярилцлага хийх, газар дээр нь нөхцөл байдалтай танилцаж, ажиглалт хийх зэрэг судалгааны нийтлэг арга зүйг баримталсан.

Судалгаа №01-ийн хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсээс шүүх хуралдааны тэмдэглэлийг хуулийн хугацаанд албажуулсан¹ байдал, Шүүхийн захиргааны хүний нөөцийн газраас шүүх хуралдааны нарийн бичгийн даргын 2023 оны сул орон тооны нөхөн бүрдүүлэлтийн талаар статистик тоон мэдээ гаргуулан авсан.

¹ ЗХШХШТХ 88.3.Шүүх хуралдаан дууссан өдрөөс хойш долоо хоногийн дотор тэмдэглэлийг бэлэн болгох ба түүнд шүүх хуралдаан даргалагч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

ИХШХШТХ 96.2.Шүүх хуралдаан дууссан өдрөөс хойш 3 хоногийн дотор тэмдэглэлийг бэлэн болгоно. Тэмдэглэлд шүүх хуралдаан даргалагч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

ЭХШХШТХ 11.8 дугаар зүйлийн 1.Шүүх хуралдааны тэмдэглэлийг шүүхийн шийдвэрийг уншиж сонсгосноос хойш 7 хоногийн дотор гаргаж, шүүх хуралдаан даргалагч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, прокурор, оролцогчид танилцуулна.



Мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процесс хуулиуд болон хэргийн хөдөлгөөний аргачлал, стандартад зааснаар шүүх хуралдааны тэмдэглэлийг хөтлөх нь Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, түүнийг хянаж албан тушаалтан нь Шүүгч, хуулийн хугацаанд албажуулж байгаа явцад хэргийн хөдөлгөөний хяналт хэрэгжүүлэх нь тухайн шүүхийн Тамгын газрын дарга болон Хэлтсийн дарга нар байх тул судалгааны үнэн бодит, үндэслэл бүхий байх зарчмыг баримтлан дээрх оролцогчдыг хамруулан асуулга боловсруулж, Google drive цахим систем ашиглан судалгааг асуулгаар авч нэгтгэн түүнд дүн шинжилгээ хийсэн.

Газар дээр нь очиж нөхцөл байдалтай танилцсан буюу Нийслэлийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нартай ярилцаж, систем ашиглалтын нөхцөл байдалд ажиглалт хийсэн.

Судалгаа №02, 03-ын хүрээнд асуулга боловсруулан анхан болон давж заалдах шатны шүүхийн нийслэл дэх болон орон нутаг дахь шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарыг оролцуулан Google drive цахим систем ашиглан асуулгаар судалгааг авч нэгтгэн түүнд дүн шинжилгээ хийсэн.

Газар дээр нь очиж нөхцөл байдалтай танилцсан буюу Нийслэлийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нартай ярилцаж, систем ашиглалтын нөхцөл байдалд ажиглалт хийсэн.





СУДАЛГААНД ОРОЛЦСОН ШҮҮХ ХУРАЛДААНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА НАРЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Судалгаанд оролцогчдын харьяалал

2023 оны хагас жилийн байдлаар анхан болон давж заалдах шатны шүүхэд 230 орчим² ШХНБД ажиллаж байгаа бөгөөд 73 хувь нь (168) энэхүү судалгаанд хамрагдсан байна. Үүнээс 50.6% буюу 85 ШХНБД нь нийслэлд, 30.4% буюу 51 ШХНБД нь аймагт, 19% буюу 32 ШХНБД нь сум дундын шүүхэд ажилладаг байна.

Судалгаанд хамрагдсан ШХНБД нарыг анхан болон давж заалдах шатны шүүхэд ажиллаж байгаа байдлыг график 1-ээр харуулав.

График 1. Анхан болон давж заалдах шатны шүүхэд ажиллаж буй ШХНБД (Давхардсан тоогоор)



Дээрх график 1-ээс харахад судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 77 хувь нь анхан шатны шүүхэд ажилладаг байна.

Судалгаанд оролцогчид ямар төрлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог болохыг график 2-оор харуулав.


График 2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрөл /Давхардсан тоогоор/



График 2-оос харахад давхардсан тоогоор дийлэнх нь иргэний болон эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд оролцдог байх бөгөөд энэ нь иргэн, эрүүгийн хэргийн шүүх хуралдаан нь хэргийн тооноос хамаарч товлогддогтой харилцан хамааралтай байна.

Зарим ШХНБД 2-4 төрлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог байх бөгөөд график 3-аар харуулав.

График 3. Хоёроос дөрвөн төрлийн ажиллагаанд оролцох буй байдал (Давхардсан тоогоор)



² ШЕЗ-ийн Шүүхийн захиргааны хүний нөөцийн албаны мэдээлэл




Дээрх график 3-аас үзэхэд 35.1% зөвхөн иргэний хэргийн, 19.6% нь зөвхөн эрүүгийн хэргийн, 13.7% нь зөвхөн захиргааны хэргийн, нийт 68.4% нь нэг төрлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог бол үлдсэн 31.6% нь 2-оос дээш төрлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог байна.

2. Судалгаанд оролцогчдын ажилласан жил

Судалгаанд оролцогчдын ажилласан жил, туршлага нь судалгааны үр дүнг тодорхойлоход ач холбогдолтой тул ажилласан жилийн байдлыг график 4-өөр харуулав.

График 4. Шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалд ажилласан хугацаа



Судалгаанд оролцогчдын ажилласан жилийн байдлыг харахад 48% нь шинээр томилогдсон, томилогдоод удаагүй буюу 1 жил хүртэл хугацаанд ажилласан байна. Харин үлдсэн 52% нь ШХНБД-аар 1-ээс дээш жил ажилласан тодорхой хэмжээнд туршлага хуримтлуулсан гэж үзэхээр байна. Мөн нийт 168 оролцогчоос 50 орчим хувь нь шинээр томилогдсон, томилогдоод удаагүй байгаа нь хүний нөөцийн тогтворгүй байдалтай холбоотой гэж үзэхээр байна.

д/д	Удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалт зарлагдсан албан тушаал	Сул орон тоо	Шалгалтад бүртгэгдсэн иргэдийн тоо	Шалгалтад оролцсон иргэдийн тоо	Тусгай шалгалтын үр дүнгээр албан тушаалд томилогдсон иргэдийн тоо
1	ШЕЗ-ийн удирдах болон гүйцэтгэх албан тушаал	10	15	7	5
2	Улсын дээд шүүхийн Тамгын газрын гүйцэтгэх албан тушаал	29	22	7	7
3	Шүүхийн үйлчилгээний хэлтсийн дарга	6	13	9	6
4	Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн	16	30	20	12
5	Мэдээллийн технологийн мэргэжилтэн	15	5	3	3
6	Шүүхийн зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн	3	8	4	2
7	Шүүгчийн туслах	76	16	10	10
8	Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга	61	199	157	56
	Бүгд	216	308	217	99

**ШХНБД НАРЫН УР ЧАДВАРЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ:****1.Шүүх хуралдаанд оролцож буй тоо**

ШХНБД нарын ажлын 5 хоногт шүүх хуралдаанд оролцож буй байдлыг хүснэгт 1-ээр, нэг өдөрт шүүх хуралдаанд оролцож буй байдлыг хүснэгт 2-оор тус тус харуулав.

Хүснэгт 1. Ажлын 5 хоногт оролцож байгаа шүүх хуралдааны дундаж тоо:³

Шүүхийн байршил	1-5 хүртэл	6-10 хүртэл	11-15 хүртэл	D. 16-19 хүртэл	20 –оос дээш	Нийт
Нийслэл	1	14	32	33	5	85
Аймаг	2	10	15	24	0	51
Сум дундын шүүх	1	10	13	8	0	32
Нийт	4	34	60	65	5	168

Хүснэгтээс үзвэл нийт судалгаанд оролцогчдын 38 буюу 22.6% нь 10 хүртэл хуралд, 125 буюу 74.4% нь 11-19 хуралд, 5 буюу 3% нь 20-оос дээш хуралд оролцдог гэж хариулсан байна. Үүнээс үзвэл судалгаанд оролцогчдын дийлэнх нь ажлын 5 хоногт дунджаар 20 орчим шүүх хуралд оролцдог гэж үзэхээр байна.

Хүснэгт 2.Өдөрт оролцож байгаа шүүх хуралдаан /оролцогчдын тоогоор/

Өдөрт оролцож байгаа шүүх хуралдаан	1 цаг хүртэл	1-ээс 2 цаг	3-аас 4 цаг	5-аас 8 цаг	8 цагаас дээш	харилцан адилгүй	нийт
	11	48	48	47	11	3	168

Судалгаанд оролцогчдын 11 буюу 6.5% нь 1 цаг хүртэл, 48 буюу 28.6% нь 1-2 цаг, 48 буюу 28.6% нь 3-4 цаг, 47 буюу 28% нь 5-8 цаг, 11 буюу 6.5% нь 8 цагаас дээш, 3 буюу 1.8% нь харилцан адилгүй гэсэн хариулт өгсөн байна. Үүнээс үзвэл өдөрт 1-8 цаг хуралд оролцдог, харилцан адилгүй байна.

2.Шивэх хурд

Практикт шүүхийн тамгын газрын дийлэнх нь ШХНБДаргыг бичээчийн сургалт төгссөн байхыг шаарддаг бөгөөд албан бус мэдээллээр Монгол Японы төвийн бичээчийн сургалтыг төгсөгч нарын 1 минутад бичих тэмдэгтийн хурдны дээд амжилт нь 500 тэмдэгт бол дундаж нь 200 тэмдэгт байдаг байна.

Судалгаанд оролцогчдын 1 минутад бичих тэмдэгтийн хурдыг график 5-аар харуулав.

График 5. ШХНБД-ын 1 минутад бичих тэмдэгтийн хурд

³ Хавсралтаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрлөөр ажлын 5 хоногт оролцож байгаа шүүх хуралдааны дундаж тоог харуулав.




Дээрх графикаас харахад нийт 168 оролцогчийн 112 буюу 66.7 хувь нь 1 минутад 200 хүртэл тэмдэгт бичдэг байна. Харин үлдсэн 33.3 хувь нь 1 минутад 201-ээс дээш тэмдэгт бичдэг байна.

3.Боловсруулалт хийх хугацаа

ШХНБД 1 цаг үргэлжилсэн шүүх хуралдааны тэмдэглэлийг шүүх хуралдааны явцад ямар хэмжээнд боловсруулсан байгаагаас шалтгаалаад хуралдаан дууссаны дараа боловсруулалтыг хийж дуусгахад ямар хугацаа зарцуулж байгааг график 6-аар харуулав.

График 6. Нэг цаг үргэлжилсэн шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөхөд зарцуулж буй хугацаа: Графикт оролцогчдын тоогоор харуулав.



Дээрх графикаас үзэхэд шүүх хуралдааны тэмдэглэлийг хурлын үеэр:

- 81-100 хувийг шивсэн тохиолдолд 30 хүртэл минут,
- 60-80 хувийг шивсэн тохиолдолд 1 хүртэл цаг,
- 40-60 хувийг шивсэн тохиолдолд 1-2 хүртэл цаг,
- 0-30 хувийг шивсэн тохиолдолд харилцан адилгүй хугацаа зарцуулдаг болох нь харагдаж байна.

Үүнээс харахад ШХНБД нар шүүх хуралдааны үеэр тэмдэглэлээ аль болох бүрэн бичсэнээр хуралдааны дараа боловсруулалт хийхэд бага хугацаа зарцуулахаар байна.

ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХУУЛИЙН ХУГАЦААНД БАТАЛГААЖУУЛАХАД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ:

Энэхүү хэсгийн судалгаанд нийт 189 албан тушаалтан оролцсон бөгөөд үүнээс 17 нь тамгын газрын дарга, 22 нь хэлтсийн дарга, 94 нь шүүгч, 56 нь ШХНБД байна.

Нийт 56 ШХНБД нарын 43 нь анхан шатны шүүхэд, 9 нь давж заалдах шатны шүүхэд, 4 нь анхан болон давж заалдах шатны шүүхэд ажиллаж байна.

Шүүх хуралдааны тэмдэглэлийг хуулийн хугацаанд баталгаажуулахад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулахын тулд хугацаа хэтэрч байгаа тохиолдлын тоог шүүгч, тамгын газрын дарга, хэлтсийн дарга, ШХНБД тус бүрээр тодорхойлуулахаас гадна Шүүхийн ерөнхий зөвлөлийн Мэдээлэл технологийн газрын Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсийн гаргасан судалгааг харьцуулав.



Иргэн

№	Огноо	Улирал	Нийт тэмдэглэл	Үүнээс		
				Хугацаандаа	Хугацаа хэтэрсэн	
					тоогоор	хувиар
1	2022	I	13486	6758	6728	49.89
2		II	16473	7153	9320	56.58
3		III	10276	5824	4452	43.32
Нийт			40235	19735	20500	50.95
4	2023	I	15308	10417	4891	31.95
5		II	16693	10821	5872	35.18
6		III	10363	7313	3050	29.43
Нийт			42364	28551	13813	32.61

Эрүү

№	Огноо	Улирал	Нийт тэмдэглэл	Үүнээс		
				Хугацаандаа	Хугацаа хэтэрсэн	
					тоогоор	хувиар
1	2022	I	3855	496	3359	87.13
2		II	4103	645	3458	84.28
3		III	2895	560	2335	80.66
Нийт			10853	1701	9152	84.33
4	2023	I	3644	827	2817	77.31
5		II	3617	1020	2597	71.80
6		III	2721	859	1862	68.43
Нийт			9982	2706	7276	72.89

Захиргаа

№	Огноо	Улирал	Нийт тэмдэглэл	Үүнээс		
				Хугацаандаа	Хугацаа хэтэрсэн	
					тоогоор	хувиар
1	2022	I	1681	1548	133	7.91
2		II	2047	1387	660	32.24
3		III	1828	1680	148	8.10
Нийт			5556	4615	941	16.94
4	2023	I	2066	1987	79	3.82
5		II	1982	1968	14	0.71
6		III	1518	1360	158	10.41
Нийт			5566	5315	251	4.51



График 7. ШХНБД нарын хугацаа хэтрүүлж буй байдлыг ажилласан жилээр нь харуулбал:




График 8. ШХНБД нарын хугацаа хэтрүүлж буй байдлыг шүүхийн байршлаар нь харуулбал:





График 9. Хугацаа хэтрүүлж буй байдлыг албан тушаалтан бүрийн үнэлгээгээр харуулбал:



Дээрх графикаас үзвэл Тамгын газрын дарга нар хугацаа хэтрэлтийг заримдаа, хэлтсийн дарга нар заримдаа болон хааяа гэж тодорхойлсон бол өдөр тутам гардан хэрэгжүүлж буй шүүгч болон ШХНБД нар хааяа гэж тодорхойлсон байна.

Шүүх хуралдааны тэмдэглэлийг хууль заасан хугацааг хэтрүүлж буй шалтгааныг график 10-аар харуулав.

**График 10. Шүүх хуралдааны тэмдэглэлийг хуульд заасан хугацааг хэтрүүлж албажуулж буй шалтгаан нөхцөл. /Оролцогчийн хувь, тоог давтагдсан утгаар/**

Дээрх графикаас үзвэл өдөрт олон шүүх хуралдаанд дараалж орох, маргааны үйл баримтыг ойлгоогүйгээс холбогдох мэдээллийг тодруулах, хүний нөөц тогтворгүй, тэмдэглэл хянах, боловсруулалт хийх хугацаа бага, нэг дор олон хуралдаан шахаж товлодог зэрэг нь шүүх хуралдааны тэмдэглэлийг хуулийн хугацаанд албажуулахад хамгийн их нөлөөлж буй хүчин зүйлс гэж үзэхээр байна.

Мөн дээрх шалтгаан нөхцөлүүдээс орхигдсон хүчин зүйлсийн тухайд нээлттэй асуумжид судалгаанд оролцогчид дараах шалтгаан нөхцөлийг тодорхойлсон байна.

Нийслэлийн анхан болон шатны ШХНБД нар:

- Шүүгч нарын тоо нэмэгдсэнтэй холбоотой орон тооны нэмэгдэл дутмаг
- Шийтгэх тогтоол, тогтоох хэсгийг тэмдэглэл дээр хуралдаан дээр уншсан байдлаар сонсоод бичихээр дараа нь заавал засвар орох хэрэг гардаг, дахин хэвлэж албажуулахаар хугацаа нь хэтэрсэн байдаг.
- Нэг нарийн бичиг 3 шүүгчийн хуралд суудаг тул амжихгүй байх тохиолдол байдаг
- Ачаалал их, хурлын тэмдэглэлээс гадна архив болон гүйцэтгэх хуудас бичдэг учир хуулийн хугацаанд тэмдэглэлээ гаргах боломж байхгүй.
- Шүүгчийн туслахын чиг үүргийн ажлаас хийхийг үүрэг болгодог. Тэмдэглэл хугацаанд гараагүй байхад давхар шүүгчийн туслахын тов мэдэгдэх гэх мэт ажил хийх нь саад учруулдаг.



- шүүхийн ачаалал их, шүүх хуралдаан товлосон цагтаа ороогүйн улмаас зааланд хий дэмий цаг үрж суудаг.

Давж заалдах шатны ШХНБД нар:

- Магадлал гарсны дараа тэмдэглэл гардаг, магадлалаас илтгэж, тогтоох хэсгийг оруулдаг учраас заримдаа хугацаа хэтэрдэг.
- Зарим өдөрт 9-12 шүүх хуралдаанд ордог. Нэг шүүх хуралдаан 40 минут, зарим нь 120-180 минут ч орох тохиолдол байгаа. Иймд өдөрт 12 хуралд ороход бүгдийг нь 7 хоногийн хугацаанд гаргах шаардлагатай байдаг.

Аймгийн анхан шатны ШХНБД нар:

- Хуульд заасан хугацаа бага, ачаалал их
- Шүүгч чөлөө авсан үед /ховор тохиолдолд/

Аймгийн давж заалдах шатны ШХНБД нар:

- Эрүүгийн шүүх хуралдааны тэмдэглэлийн хувьд олон оролцогчтой урт хугацааны /2-4/ байнга шахуу маргаантай хурал ордог учир өдөржин хуралд орж гарч ирээд тэмдэглэлээ үргэлжлүүлээд оройн цагаар бичээд суухад хүндрэлтэй байдаг. Эрүүгийн шүүх хуралдааны тэмдэглэл нь бусад шүүх хуралдааны тэмдэглэлүүдийг бодоход харьцангуй олон хуудастай харьцангуй маргаантай ордог учир хуулийн хугацаанд баталгаажуулахад асуудал тулгардаг. Өдөрт дунджаар 2-3 ердийн эрүүгийн шүүх хуралд ороод дахин хялбар хэрэг өдөрт болон 7 хоногт хэд хэд ирээд шууд зарлагдаад ордог учир ачаалал маш их байдаг. Нарийн бичгийн дарга нарыг эрүүгийн нарийн бичиг иргэний нарийн бичиг захиргааны нарийн бичиг гэж дагнаж оруулснаар нэг хүнд хэтэрхий их ачаалал ирж тэмдэглэлээ хуулийн хугацаанд баталгаажуулж чадаагүйгээс үүсэх үр дагавар олон байдаг. Аль болох шөнө оройгүй сууж тэмдэглэлээ хуулийнхаа хугацаанд баталгаажуулах гэж хичээдэг.
- Шүүгч хянахад хугацаа их ордог
- шийдвэрийн тогтоох хэсгээс авах шаардлага тавьдаг учраас шийдвэрээ гаргахыг хүлээдэг


Сум дахь сум дундын шүүхийн ШХНБД нар:

- Иргэн 2014 систем шүүх хуралдааны тэмдэглэлийг хугацаанд хийсэн боловч шүүгчийн туслахын эрхээр баталгааждаг учраас хугацаа алддаг. Үүнийг нарийн бичиг өөрийн эрхээр баталгаажуулах шаардлагатай
- Шүүхийн шийдвэр болон шийтгэх тогтоолын тогтоох хэсэг 2 долоо хоногт гардаг учир тогтоох, захирамжлах хэсгийг хүлээгээд ихэвчлэн хугацаа хэтэрдэг. Мөн иргэний хэргийн шүүх хуралдааны тэмдэглэлийн хуулийн хугацаа богинохон. Маргаантай хурлын тэмдэглэлийг 3 өдөрт амжихгүй. Хуралд суух, бусад ажлыг амжуулах гээд хоцордог.
- Маргаантай, маргаангүй олон цаг орсон хурлаас шалтгаална
- эрх зүйн акт оруулахад программ гацаж хугацаа алддаг.

Шүүх хуралдааны тэмдэглэлийг хугацаа хэтрүүлж буй шалтгаан нөхцөлийг дан ганц шүүх хуралдааны нарийн бичгийн даргаар тодорхойлуулах нь өрөөсгөл тул шүүгч, тамгын газрын дарга, хэлтсийн дарга нараар мөн тодорхойлуулсныг график 11-ээр харуулав.



График 11. Шүүх хуралдааны тэмдэглэлийг хуульд заасан хугацааг хэтрүүлж албажуулж буй шалтгаан нөхцөл



Мөн шүүгч, Тамгын газрын дарга, хэлтсийн дарга нараас шүүх хуралдааны тэмдэглэлийг хуулийн хугацаанд албажуулахад нөлөөлж буй шалтгаан нөхцөлүүдээс орхигдсон хүчин зүйлсийг тодруулахад дараах шалтгаан нөхцөлийг тодорхойлсон байна.

Тамгын газрын дарга:

- Тэмдэглэл бичих хуульд заасан хугацаанд өөрчлөлт оруулах. Жишээ нь: иргэний шүүх хуралдааны тэмдэглэлийг ажлын 5 өдөр гэх мэт.
- Ихэнх нарийн бичгийн дарга шүүгчийн туслахын албан үүргийг түр орлон гүйцэтгэж ажлын ачаалал их байна.
- Ажлын 8 цагтаа шүүх хуралдаантай байдаг учир ажлын бус цагаар тэмдэглэлээ бичих шаардлага тулгардаг.
- Нарийн бичгийн ур чадварыг нэмэгдүүлэх сургалтад хамруулах

Хэлтсийн дарга:



- Шүүх хуралдааны нарийн бичгийн даргын ачаалал их байна 1 шүүгч 1 нарийн бичгийн даргатай байх шаардлагатай.
- Иргэний хэргийн шүүх хуралдааны тэмдэглэлийг 3 хоногийн дотор гаргаж, программд хаалт хийхэд хугацааны хувьд шахуу байдаг. Иймд иргэний хэргийн шүүх хуралдааны тэмдэглэлийг бусад эрх зүйн маргааны хуралтай адил 7 хоногийн дотор гаргаж, программд хаалт хийж байхаар нэн яаралтай зохицуулах шаардлагатай гэсэн саналыг гаргаж байна.
- Ихэвчлэн хувийн зохион байгуулалт муугаас тэмдэглэл албажих хуулийн хугацааг хэтрүүлдэг. Мөн зарим тохиолдолд даргалагч шүүгч, өвчтэй, чөлөөтэй, албан томилолт, ээлжийн амралттай үед гарын үсэг зурж албажуулах ажиллагаа хойшлогддог.
- Захиргааны ажилтны мэргэшүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулах, ШХНБД нарын ажлын байрны тогтвортой нөхцөлийг хангахаар эрх зүйн орчинг бүрдүүлэх, энэ орчин бүрдэхгүйн улмаас ШХНБД нар их солигдож тэмдэглэл хугацаандаа гарахгүй тохиолдол гардаг.
- Монгол хэлний дүрэм мэдэхгүй шинээр орж буй ажилтнууд сүүлийн үед нэмэгдэж байна.
- Чанартай хүний нөөцийг ШЕЗ-өөс бүрдүүлж өгч байх.

Шүүгч:

- Зарим шүүх хуралдааныг тэмдэглэлийг аудио хувилбарт оруулах хэрэгтэй /маргаангүй/
- Сэтгэл, ажлын хурд, гэр бүлийн нөхцөл зэргээс бас шалтгаалдаг.
- Шүүхийн тамгын газрын хүний нөөцийн бодлого сул.
- Ажлын ачаалал их, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга 2 шүүгчийн дунд нэг, ажлын 5 өдөр хуралд суудаг, дараа 7 хоногтоо багтааж гаргаж өгөх цаг хугацаа их шаарддаг.
- Шинээр ажилд орж буй нарийн бичгийг дадлагажуулах ажил муу. Бичиг үсгийн чадвар, монгол хэлний найруулга зүй зэргийг заадаг байх.
- Тамгын газар зохион байгуулалт маш муу хийдгээс бас шалтгаалж байна.
- Үг, үсгийн алдаа нэг бүрчлэн засдаг, хурал дээр яригдсан зүйл агуулгын хувьд ойлгомжгүйгээр орж ирснийг дахин сонсож засан шаардлага тавьдаг зэргээр хянаснаа дахин дахин хянах шаардлага гараад байна. Бланклаад ирсэн тэмдэглэлийг хүртэл өмнөх засвартайгаа тулгаж харахгүй бол алдаа их гараад байгаа. Энэ нь шүүхийн ажил муу явагддаг гэсэн ойлголтыг хэргийн оролцогч болох иргэн, хуулийн этгээдэд төрүүлдэг. Өөрөөр хэлбэл шүүхийн нэр хүндийн асуудал давхар явна, нөгөөтээгүүр хэргийн гол бүрдэл хэсэг учир хариуцлагатай хандах шаардлагатай.
- Шүүгчийн туслах тэмдэглэлийг хянадаггүй, Шүүгч тэмдэглэлийг өдөрт нь хянаж өгдөг. 2 шүүгчийн дунд 1 нарийн бичиг байгаагаас ажлын 5 өдөр тасралтгүй шүүх хуралд орж тэмдэглэлээ гүйцээж гаргах боломжгүй байдаг.
- Тухайн 7 хоногт хийгдсэн шүүх хуралдааны тэмдэглэлийн тал нь буюу 50% нь хугацаандаа гарч, хэрэгт үдэгддэг бол үлдэх хувь нь хуульд заасан хугацаа дуусах өдөр буюу түүнээс хойш шүүгчид хянуулахаар шилжүүлдэг. Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журамд зааснаар ажилтны боловсруулсан аливаа баримт



бичгийн төслийг эрх бүхий албан тушаалтан ажлын 2 өдрийн дотор хянах зохицуулалт байдаг. Тэгэхээр хуульд заасан хугацааг хэтрүүлсэн гэдгийг түүнийг хянах хугацааг харгалзаагүйтэй холбоотой гэж харж байна.

- Тамгын даргын ажлын зохион байгуулалт, ажлын цаг барьж ажиллах, цаг ашиглалтыг сайжруулах.

ШХНБД нарын шүүх хуралдааны тэмдэглэл хугацаа хэтрүүлж буй хугацааг албан тушаалтан бүрээр график 12-оор харуулав.

График 12. Тэмдэглэлийг хуулийн хугацаа хэтрүүлж албажуулж буй хугацаа:




График 12-оос харвал шүүх хуралдааны тэмдэглэлийг хугацаа хэтрүүлж буй хугацааг тамгын газрын дарга, хэлтсийн дарга болон шүүгчид 6-7 хоног хугацаа хэтэрдэг гэж нийтлэг байдлаар тодорхойлсон байна.

Шүүх хуралдааны нарийн бичгийн даргын найруулга зүй хийх ур чадвар болон шивэх хурдны талаарх өөрийн үнэлэмжийг график 13, 14-өөр харуулав.

График 13. Найруулга зүй хийх ур чадвар







График 14. Шивэх чадвар (нэг минутад)



Практикт шүүх хуралдааны тэмдэглэлийг шүүгчээс гадна шүүгчийн туслах давхар хянадаг бөгөөд энэ нь шүүх хуралдааны тэмдэглэлийг хуулийн хугацаанд албажуулахад нөлөөлөх эсэхийг тодорхойлох хүрээнд тохиолдлын тоог график 15, 16-аар харуулав.

График 15. Шүүх хуралдааны тэмдэглэлийг шүүгч хянахаас өмнө шүүгчийн туслах хянаж буй байдал:




График 15. Шүүх хуралдааны тэмдэглэлийг шүүгчийн туслах болон шүүгчээр хянуулахад зарцуулагдаж буй хугацаа:



Шүүгчийн туслах



Шүүгч



График 15-аас үзэхэд шүүх хуралдааны тэмдэглэлийг шүүгчээс өмнө шүүгчийн туслах хянаж буй тохиолдолд багагүй байх бөгөөд график 16-аас харахад шүүгчийн туслахын хувьд харилцан адилгүй хугацаа зарцуулдаг бол шүүгчийн хувьд ихэвчлэн бүтэн өдрөөс дээш хугацаа зарцуулдаг болох нь харагдаж байна.

Шүүх хуралдааны тэмдэглэлийг хуулийн хугацаанд албажуулах ажлыг сайжруулах санал:

Нийслэлийн анхан шатны ШХНБД нар:

- Шүүх хуралдааны нарийн бичгийн даргын орон тоог нэмэх, шүүгч бүр өөрийн гэсэн нарийн бичигтэй болох, нарийн бичгийн дарга нарын ачааллыг тэнцвэржүүлэх.
- Программ гацах асуудал их байдаг.
- Шүүгчээс хянагдаж ирэх хугацаа их байдаг.
- Шүүгчид хянуулах бус шүүх хуралдааны нарийн бичгийн даргаас гардаг эрхийн акт байх тул өөрөө хянаж хариуцлага хүлээх түвшинд байвал хуулийн хугацаанд гарахад сайжрах байх. Шүүх хуралдааны тэмдэглэл хурлын процессыг бүгдийг оруулдаг тул өөрийн эрх мэдлийн хүрээнд албажуулж гаргах хэрэгтэй гэж бодож байна.
- Шүүх хуралдааны тэмдэглэл гарах хугацааг уртасгах тогтоол, захирамж гардаг хугацаатай ижил байвал ажлын ачаалал бага, тэмдэглэл саадгүй гарна.
- Шүүхэд ажиллаж буй нарийн бичгийн дарга нар тогтворгүй байдгаас үүдэн хүний нөөц хомс байдаг, ажлын өдрүүдэд хуваарилагдаагүй шүүгч нарын хуралд ордог. Мөн хурлын зааланд хэн нэгэн оролцогч ирээгүйгээс үүдэн маш олон цагийг хий дэмий өнгөрөөж суудаг. Хамгийн гол хүчин зүйл нь хүний нөөцийн хомсдолтой байгаа. Иймд ачаалалттай байгаа тул албажуулах хугацааг хэд хоногоор нэмэх нь зүйтэй гэж үзэж байна. Мөн зарим өдөр маш олон цагийн хуралд эсвэл маш олон хуралд суудаг учир тэр бүр 7 хоногийн дотор тэмдэглэл албажиж гарах боломжгүй нөхцөл байдал байдаг.
- Хүний нөөцийн асуудлаа яаралтай шийдэх хэрэгтэй байна. Ялангуяа сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх хурал маш их байдаг. Энд нэг нарийн бичиг хоёр шүүгч дээр явах боломжгүй. Учир нь хэргийн агуулга, хэргийн цар хүрээ өргөн учраас тэр хэрээр хэргийн оролцогчдын тайлбар маш их байдаг.



Өдөр болгон 9-10 хуралд ордог учраас хүний нөөцийн асуудлыг яаралтай шийднэ үү!

- Тэмдэглэл оруулах хугацааг уртасгаж өгнө үү. Зарим хурлууд 2-3 цаг ордог тул бичихэд хугацаа бага байдаг. Амралтын 2 хоногт амрахгүй бичээд 1 дэх өдрийн хуралдаа ямар ч эрч хүчгүй ажилладаг. Тэмдэглэл оруулах хугацааг нь уртасгах зайлшгүй шаардлагатай байна.

Давж заалдах шатны ШХНБД нарын хувьд:

- Шүүх хуралдааны тэмдэглэл бэлэн болсон боловч магадлал гарахыг хүлээдэг. Өөрөөр хэлбэл, магадлал гарсны дараа тэмдэглэлээ баталгаажуулж, албажуулдаг.

Аймгийн анхан шатны ШХНБД нар:

- Орон тоог нэмэх, шүүгч шүүгчийн туслах, нарийн бичгийн дарга нарын ажлын уялдаа холбоог сайжруулах, хэргийн материал тэмдэглэл тогтоол шийдвэрийн датаг богино хугацаанд хадгалах бааз үүсгэж хэрэгтэй мэдээллээ богино хугацаанд авч болох боловсронгуй цахим систем нэвтрүүлэх.

Аймгийн давж заалдах шатны ШХНБД нар:

- 1 шүүхийн тамгын газарт хэдэн нарийн бичгийн дарга нар байдаг талаар судалгаа гаргаж, нийт орж байгаа хурлын тооноос хамаарахгүйгээр орж байгаа хурлын маргаан үргэлжлэх хугацаа гарч байгаа тэмдэглэлийн хуудасны тоонд дүгнэлт хийж хяналт тавьж ачаалал тэнцвэржүүлчихвэл тэмдэглэлийн хугацаа хэтрэхгүй, эрүүгийн нарийн бичгийн хувьд бусад нарийнуудыг бодоход үнэхээр ачаалал их гарч байгаа тэмдэглэлүүд 20-40 хуудас тогтмол гардаг учир хэдэн өдөр бичиж тэмдэглэл гардаг. Иймд ачаалал тэнцвэржүүлж өгнө үү.
- Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах
- Шүүгчийн хянах хоногийг нэмэх, шүүгчийн туслах хянан гэвэл улам удааширна.


Сум дахь сум дундын шүүхийн ШХНБД нар:

- Иргэн-2014 системд шүүх хуралдааны тэмдэглэл баталгаажуулах эрхийг шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарт нээж өгөх, Эрүүгийн бүртгэлийн хяналтын системд шүүгчийн туслах нар нарийн бичгээ сонгож өгөх.
- Шүүх хуралдааны тэмдэглэл албажуулах хугацааг нэмж, шийдвэр гарах хугацаатай адилхан болговол шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарын зөрчил гарахгүй байх боломжтой.
- программын хурд, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх.




График 16. ШХНБД нарын найруулга зүй хийх ур чадвар болон шивэх хурд

Найруулга зүй



Шивэлтийн хурд



Ажлын зохион байгуулалт



Шүүх хуралдааны тэмдэглэлийг хуулийн хугацаанд албажуулах ажлыг сайжруулах санал /Шүүгч, Тамгын газрын дарга, хэлтсийн дарга/:

- Иргэний хурлын албажуулах хугацааг нэмэх, ажлын ачааллыг бууруулах.
- Ажлын ачааллаас болж хугацаа алдах тохиолдол гардаг. Дууны бичлэгийг текстэд хөрвүүлэх программыг боловсронгуй болгох. Хүний нөөцийг бүрдүүлэх явцыг хурдасгах.
- Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарыг шүүгч тус бүрээр дагнаж ажиллуулбал зохистой байдаг.
- Иргэний хэргийн шүүх хуралдааны тэмдэглэл гаргах хуульд заасан хугацаанд өөрчлөлт оруулах шаардлагатай байна.
- шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарыг туршлагажуулах, хувийн зохион байгуулалтыг сайжруулах.
- тэмдэглэл гаргах хуулийн хугацааг уртасгах, хурал хоорондын цагийн зохион байгуулалтыг зөв төлөвлөх.




- Зарим шүүх хуралдааныг тэмдэглэлийг аудио хувилбарт оруулах хэрэгтэй /маргаангүй/
- ШХНБД нар ажлын цаг ашиглалтаа сайжруулах, хурдтай ажиллаж сурах.
- Шинээр томилогдож буй ажилтанд ажлын байрны онцлог, ажлын байрны тодорхойлолт зэргийг танилцуулж байх.
- Иргэний шүүх хуралдааны тэмдэглэлийг баталгаажуулах 3 хоногийн хугацааг 7-10 хоног болгох. Техник технологийн дэвшлийг ашиглах.
- Иргэний хэргийн шүүх хуралдааны тэмдэглэлийг бэлэн болгох хугацааг 7 хоног болгох.
- Чимэгэ систем шиг программыг бүх шатны шүүхэд нэгэн хэвшмэл байдлаар ашиглахыг зөвшөөрөх, лиценц төлбөр мөнгөний асуудлыг нэг мөр шийдвэрлэж өгөх, шүүгч нарт тэмдэглэл хянахад өөр өөрийн арга барилаар буюу зарим шүүгч үг бүрээр бичүүлэх, зарим шүүгч зөвхөн гол агуулгыг тусгуулах зэргээр өөр өөрийн үзэмжээр тэмдэглэл бичүүлдгийг нэг мөр болгох санал оруулж байна.
- ШХНБДарга нарын ур чадавхыг нэмэгдүүлэх /үг үсгийн алдааг нь засаж их хугацаа алддаг/ мөн эрүүгийн системийн E-CASE-тэй холбох шаардлагатай, хоцрогдсон, ашиглалт тааруу систем юм.
- Процессын хуульд олон хувилбарт уян хатан зохицуулалт нэмж өгөх /тухайлбал, зарим маргаанд талуудын хэлсэн бүх зүйлийг бичих бус, онцлон тэмдэглүүлэх хэсгийг шивдэг болох гэх мэт/, Яриаг хөрвүүлэх хөрвүүлгийн программуудыг хөгжүүлж, шүүхийн үйл ажиллагаанд хурдтай нэвтрүүлэх./
- Шүүх хуралдааны нарийн бичгийг тусгайлан ШЕЗ бэлтгэх.
- Шүүхийн компьютер, техник хэрэгслийг сайжруулах, хурдтай болгох, гар, маузыг нь ажиллагаатай болгох, мөн нарийн бичгийн дарга нарыг мэргэшүүлдэг, сургадаг байх. Ажлын уялдаа холбоог сайн ойлгуулах чухал байна. Бичиг үсгийн чадвартай хүн шүүхэд орж ирэхгүй, маш их үг үсгийн, утга найруулгын алдаа гаргадаг. тэрийг засахад шүүгчид тодорхой хэмжээний цаг зарцуулах шаардлагатай болдог нь хүндрэлтэй байна. Түүнчлэн шүүх хуралдааны зааланд ашиглагдаж байгаа компьютер, техник хэрэгсэл нь бүрэн биш, маш удаан ажиллагаатай, эсхүл ажилладаггүй, хуучирч муудсанаас тэд хурал дээр шууд шивж тэмдэглэлээ хөтөлж чаддаггүй.



ЧИМЭГЭ БИЧЭЭЧ СИСТЕМИЙГ АШИГЛАЛТЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ


Нийт судалгаанд оролцсон 168 ШХНБД нараас Чимэгэ системийг ашиглаж байсан талаарх асуумжийг авахад 30 хувь буюу 50 нь ашиглаж байсан байх бөгөөд 70 хувь буюу 118 нь ашиглаж үзээгүй байна. График 18-аар харуулав.

График 17. Авиаг бичвэр болгон хувиргадаг “Чимэгэ бичээч систем”-ийг ашиглаж байсан эсэх:



Чимэгэ бичээч системийг ашиглаж байсан 50 оролцогчоос уг системийг ашиглахад хүндрэл гарч байсан эсэхийг график 19-өөр харуулав.

График 18. “Чимэгэ бичээч систем”-ийг ашиглахад хүндрэл гардаг эсэх:




Чимэгэ бичээч системийг ашиглаж байсан 50 ШХНБД нарын 25 нь системийг ашиглах үед хүндрэл гарсан гэж хариулсан бөгөөд ямар хүндрэл бэрхшээл үүсэж байсныг тодруулахад:

- Зарим бүдэг хэлсэн үнийг хөрвүүлдэггүй буруу хөрвүүлдэг үсгийн фонд зөрдөг. Жишээ нь: Ө, ү үсгийг е, у үсгээр сольж бичдэг.
- Заримдаа гацах тохиолдол гардаг.
- Утга, найруулгын алдаа гардаг.
- Хажууд буй хүний яриа давхар бичигддэг.
- Үргэлжилсэн үгийн зохиол шиг хөрвүүлэгддэг учраас цэг, таслал найруулга зүй оруулахад хүндрэлтэй байдаг.
- Тайлбар хэлж буй оролцогч сул үг их хэлсэн бол тайлбарыг нь засахад төвөгтэй. Мөн он, сар, өдөр тоогоор биш үсгээр бичигддэг. Эрүүгийн хуулийн зүйл анги мөн тоогоор биш бичгээр бичигддэг. Мөн маш замбараагүй ойлгомжгүй ярьсан оролцогчийн тайлбарыг дахин сонсож бичих шаардлага үүсдэг.
- Хэргийн оролцогчдын дуу хоолойг ялгах боломжгүй учраас хэлсэн үг бүрийг үргэлжилсэн үгээр бичдэг.




ШХНБД нараас чимэгэ бичээч системийн аль хувилбарыг ашиглаж байсныг тодруулан график 20-оор харуулав.

График 19. Чимэгэ бичээч системийн хувилбарын ашиглалт




Нийт 50 оролцогчоос 15 нь шинэчлэгдсэн хувилбарыг ашиглаж байсан байх бөгөөд үүнээс 6 оролцогч уг системийг ашиглахад хүндрэл үүсэж байсан гэжээ. Тэдгээр оролцогч нарт ямар асуудал үүсэж байсныг тодруулахад “Хэллэгээр бичигддэг бас дараа нь цэг таслал том үсэг жижиг үсэг зэргийг бичиж даргалагчаас нэхэмжлэгчээс зэрэгг тодотгол бичихэд маш их цаг ордог, хэн ярьсан нь мэдэгдэхгүй догол мөр гарахгүйгээр хөрвүүлэгддэг нь засварлахад цаг их ордог, удаан уншдаг” гэсэн байна.

График 20. Чимэгэ бичээч систем ашиглалтын хугацаа, давтамж



Чимэгэ системийг ашиглаж байсан 50 ШХНБД-ын дийлэнх буюу 40 нь 1 сараас доош хугацаанд ашиглаж байсан байна. Мөн дийлэнх буюу 42 нь шаардлагатай тохиолдолд л ашигладаг байна.

График 21. Чимэгэ бичээч систем нь дараах боломжуудтай бөгөөд ашиглах явцад тус боломжууд хэр боломжийн байсан эсэхийг үнэлүүлэхэд:



	Веб апп болон мобайл апп хувилбартай	Зөвшөөрөгдөх формат: MP3, MP4, Wav, M4a форматаас	Хөрвүүлэх бичлэгийн урт худалдаж авсан цагаас хэтрэхгүй байх ёстой бөгөөд 1 удаа оруулах файлын дээд хэмжээ 8 цаг (10GB) байна	Хөрвүүлсэн бичвэрээ шалгаж засварлах	Бичвэр дундаас үг хайна.	Сул үг ялгах функцтэй.	Монгол хэлний алдаа шалгах “Болорспелл” программтай холбогдсон
■ Маш боломжийн	12	8	7	5	6	4	7
■ Боломжийн	14	18	18	15	17	13	19
■ Заримдаа асуудал үүсдэг	11	12	12	18	11	15	10
■ Боломжгүй	6	6	7	6	8	7	4
■ Огт боломжгүй	5	4	5	5	6	9	7
■ Ашиглах шаардлага гардаггүй	2	2	1	1	2	2	3

Хүснэгт 3. 1 цаг үргэлжилсэн шүүх хуралдааны тэмдэглэлийг “Чимэгэ бичээч систем” систем ашиглан хөрвүүлэхэд хэдэн минут зарцуулдаг болон системээр хөрвүүлсэн 1 цагийн шүүх хуралдааны тэмдэглэлийн агуулга, найруулга засах, хэлбэрт оруулахад зарцуулдаг хугацааг харуулав.

Хүснэгт 3.1

	Оролцогчдын тоо	
Зарцуулж буй минут	0	2
	1	5
	2	2
	3	1
	4	1
	5	4
	10	11
	15	2
	20	6
	30	8
	40	1
	60	1
	75	1
	90	1

Хүснэгт 3.2

	Оролцогчдын тоо	
Агуулга, найруулга	0	2
засах, хэлбэрт оруулахад зарцуулдаг минут	1	2
	2	5
	5	1
	10	1
	15	3
	20	3
	25	1
	30	14
	35	1
	40	1
	45	1
	60	6
	75	1



95	1
100	1
150	1
180	1
Нийт	50


90	1
95	1
120	2
180	3
200	1
Нийт	50

График 22. “Чимэгэ бичээч систем”-ийг ашигласнаар шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөх ажилд үзүүлсэн нөлөөлөл.



Системийг ашиглаж үзсэн 50 оролцогчийн хувьд 60 хувь буюу 30 оролцогч сайнаар нөлөөлсөн, 30 хувь буюу 15 нь систем ашиглахгүй үеийн хурлын тэмдэглэл хөтлөх хугацаа болон ашигласан үеийн хугацаа ижилхэн гэжээ. Харин сөргөөр нөлөөлсөн гэсэн 5 хүний хувьд систем нь хугацаа хэмнэдэггүй, шат дамжлага ачаалал үүсгэдэг буюу дахин сонсож бичих шаардлага үүсгэж байгаа нь тэмдэглэл хөтлөхөд зарцуулдаг хугацааг ихэсгэдэг гэжээ.


График 23. Чимэгэ бичээч системийг ашиглахад нөлөөлөх хүчин зүйлсийг харуулав.



Нийт судалгаанд оролцсон 168 ШХНБД нараас системийг шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөхөд үр дүнтэй эсэхийг тодорүүлж асуусан асуултын үр дүнг график 25-аар харуулав.




График 24. “Чимэгэ бичээч систем”-ийг шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөхөд хэр боломжийн гэж үзэж байна вэ?



Нийт 168 оролцогч нарын 22.6 хувь нь маш боломжийн, 13.7 хувь нь боломжийн, 20.2 хувь нь зарим талаараа, 11.3 хувь нь боломжгүй, 8.9 хувь нь огт боломжгүй гэсэн бол 23.2 хувь нь хэлж мэдэхгүй гэж хариулсан байна.

Харин зөвхөн ашиглаж байсан хүмүүсийн хувийг харвал боломжийн гэж олонх нь үзэж бөгөөд график 26-аар харуулав.

График 25. Системийг ашиглаж байсан оролцогчдын хувьд “Чимэгэ бичээч систем”-ийг шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөхөд хэр боломжийн эсэхийг тодруулж асуухад:



Боломжгүй, огт боломжгүй гэж хариулсан оролцогчид “шүүх хуралдааны оролцогчид ихэвчлэн сул үг ашиглаж, ярьж байгаа зүйлийн утга санааг энд тэнд оруулж хэлдэг болохоор найруулж бичих шаардлага үүсдэг гэж олонх нь хариулсан бол мөн хэргийн оролцогч нар тайлбар хэлэхдээ давхардуулж хэлэх, үг өгүүлбэрийг энд тэндгүй оруулж ярьдаг учраас шүүгчид тэмдэглэлийг оруулж өгөхөөс өмнө найруулга зэрэгт хугацаа их шаарддаг гэжээ.



ДҮГНЭЛТ

Судалгаа №01: “Чимэгэ системийг нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага үүссэн эсэх тандах судалгаа”:

Судалгааны хүрээнд авсан 2022, 2023 оны хэргийн хөдөлгөөний мэдээгээр Иргэний хэргийн бүх шатны шүүх 2022 оны 3-р улирлын байдлаар нийт шүүх хуралдааны тэмдэглэлийн 50.95%, 2023 оны 3-р улирлын байдлаар 32.61% -ийг, Эрүүгийн хэргийн бүх шатны шүүх 2022 оны 3-р улирлын байдлаар нийт шүүх хуралдааны тэмдэглэлийн 84.33%, 2023 оны 3-р улирлын байдлаар 72.89%-ийг, Захиргааны хэргийн бүх шатны шүүх нийт шүүх хуралдааны тэмдэглэлийг 2022 оны 3-р улирлын байдлаар 16.94%, 2023 оны 3-р улиралд 4.51%-ийг тус тус хугацаа хэтрүүлэн албажуулсан байна.

Үүнээс үзэхэд бүх шатны шүүхийн эрүүгийн хэргийн шүүх хуралдааны тэмдэглэл хуулийн хугацаанд албажаагүй хувь 70-84 хувь, иргэний хэргийн шүүхийн шүүх хуралдааны тэмдэглэл хуулийн хугацаанд албажаагүй хувь 50 хувь орчим байгаа нь эдгээр шүүхэд шүүх хуралдааны тэмдэглэл хуулийн хугацаанд албажуулах ажиллагааг хяналт тавих, уг хувийг багасгах зайлшгүй шаардлага үүссэнийг харуулж байна.

Харин захиргааны хэргийн шүүхийн шүүх хуралдааны тэмдэглэл хуулийн хугацаанд албажаагүй хувь 20% дотор байгаа нь хэвийн гэж үзэхээр байна.

Энэ нөхцөл байдал нь шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нараас авсан асуулгаас үзэхэд судалгаанд оролцогчдын ажилласан жилийн байдал нийт 168 оролцогчоос 50 орчим хувь нь шинээр томилогдсон, томилогдоод удаагүй буюу 1 жил хүртэл ажилласан байгаа нь хүний нөөцийн тогтворгүй байдал үүсэн, энэхүү ажиллаад удаагүй байгаа нь тэдгээр ийн ур чадвар дутуу байхад нөлөөлж байна.

Практикт шүүхийн тамгын газрын дийлэнх нь ШХНБДаргыг бичээчийн сургалт төгссөн байхыг шаарддаг бөгөөд албан бус мэдээллээр Монгол Японы төвийн бичээчийн сургалтыг төгсөгч нарын 1 минутад бичих тэмдэгтийн хурдны дээд амжилт нь 500 тэмдэгт бол дундаж нь 200 тэмдэгт байдаг байна.

Дээрх графикаас харахад нийт 168 оролцогчийн 112 буюу 66.7 хувь нь 1 минутад 200 хүртэл тэмдэгт бичдэг буюу дунджаас доогуур, харин үлдсэн 33.3 хувь нь 1 минутад 201-ээс дээш тэмдэгт бичдэг буюу дундаж, дунджаас илүү хурдтай бичдэг байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүх хуралдааны нарийн бичгийн даргын 1 минутад бичих зохист хэмжээг тогтоогоогүй байгаа нь тэдгээрийн ур чадварыг бодитоор үнэлэх боломжгүй нөхцөл байдлыг үүсгэжээ.

Түүнчлэн шүүх хуралдааны нарийн бичгийн даргын ур чадвартай холбогдуулан шүүх хуралдааны тэмдэглэлийг хурлын үеэр 81-100 хувийг шивсэн тохиолдолд хянаж, албажуулахад 30 хүртэл минут зарцуулдаг, 60-80 хувийг шивсэн тохиолдолд 1 хүртэл цаг, 40-60 хувийг шивсэн тохиолдолд 1-2 хүртэл цаг, 0-30 хувийг шивсэн тохиолдолд харилцан адилгүй хугацаа зарцуулсан гэсэн хариултаас үзэхэд шүүх хуралдааны үеэр тэмдэглэлээ аль болох бүрэн бичсэнээр хуралдааны дараа боловсруулалт хийхэд бага хугацаа зарцуулж байна.



Мөн уг асуудлаар шүүгчээс авсан асуулгаар нийт оролцсон шүүгчид шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нар ажлын ачаалал их, 2 шүүгчийн дунд нэг, ажлын 5 өдөр хуралд суудаг, дараа 7 хоногтоо багтааж гаргаж өгөх цаг хугацаа их шаарддаг болон ур чадвар, хувийн зохион байгуулалт сул, тогтворгүй, тамгын газраас ажлын зохион байгуулалтыг сайжруулах шаардлагатай гэсэн байна.

Тэгвэл шүүхийн Тамгын газраас дээрх асуудлын шалтгааныг 1 шүүгч 1 нарийн бичгийн даргатай байх шаардлагатай, сургалт тогтмол зохион байгуулах гэж ихэвчлэн хариулсан байна.

Ажлын хэсэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн хүний нөөцийн газраас гаргуулан авсан судалгаанаас үзэхэд 2023 онд шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалд 61 сул орон тооны захиалгыг шүүхийн Тамгын газраас ирүүлж түүний 56 сул орон тоог нөхсөн гэжээ.

Иймд судалгаа №01-ийн мэдээлэлд үндэслэн дараах дүгнэлтэд хүрч байна:

1. Эрүү, иргэний хэргийн шүүхийн шүүх хуралдааны тэмдэглэл хуулийн хугацаанд албажаагүй хувь /30-84%/ маш өндөр байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах, хэргийн оролцогчдын эрхийг зөрчих, шүүхэд итгэх итгэлийг бууруулахад сөргөөр нөлөөлөх хэмжээнд хүрсэн байна.

2. Шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалд ажиллаж байгаа хүний нөөц тогтворгүй, түүнтэй холбоотойгоор ур чадваргүй байдал үүссэн байна.

3. Шүүх хуралдааны нарийн бичгийн даргын ажлын ачаалал өндөр байна.

4. Шүүх хуралдааны нарийн бичгийн даргын зөв бичих, утга найруулга зүй, хурдтай бичих ур чадварыг сайжруулах сургалтыг тогтмол хийх шаардлагатай байна.

5. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүх хуралдааны нарийн бичгийн даргын 1 минутад шивэх дундаж хурд, зохист хэмжээг тодорхойлох шаардлагатай байна.

6. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүх хуралдааны тэмдэглэлийг хуулийн хугацаанд албажуулах талаар шүүхийн Тамгын газрын хэргийн хөдөлгөөний хяналт, ажлын уялдаа, зохион байгуулалтыг сайжруулах цогц арга хэмжээ авах /сарын аян зохион байгуулах гэх мэт/ шаардлагатай.

Дээрх нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд эрүү, иргэний хэргийн шүүхийн шүүх хуралдааны тэмдэглэл хуулийн хугацаанд албажуулах ажлыг яаралтай зохион байгуулах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх шаардлага бий болжээ.

Энэ хүрээнд оролцогчдын саналын дагуу нэг шүүгч нэг шүүх хуралдааны нарийн бичгийн даргатай болох эсхүл Чимэгэ авиаг бичвэрт хөрвүүлэх системийг ашиглах гарц байна.

Хэрэв шүүгч бүр 1 шүүх хуралдааны нарийн бичгийн даргатай болсон тохиолдолд одоо улсын хэмжээнд анхан болон давж заалдах шатны шүүхэд ажиллаж



байгаа 493⁴ шүүгч, 273⁵ шүүх хуралдааны нарийн бичгийн даргын зөрүү 220 шүүх хуралдааны нарийн бичгийн орон тоог нэмэгдүүлэхээр байх бөгөөд түүний 1 жилийн цалингийн санд урьдчилсан тооцоогоор 4,179,288,960 /1,583,064⁶*220*12сар/ төгрөгийн цалингийн сан нэг жилд шаардагдахаар тооцоо гарч байна.

Түүнчлэн шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалын тогтвортой байдлыг хангах хүрээнд тус албан тушаалын тодорхойлолтод “эрх зүйч” байхыг шаардахгүйгээр бусад мэргэжлийн хүнийг хурдан бичээчээр сургаж ажиллуулах нь үр дүнд хүрч болохоор байна.

Судалгаа №02: “Чимэгэ систем ашиглалтын явц дахь мониторингийн судалгаа”, судалгаа №03: “Чимэгэ систем хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа”:

Нийт судалгаанд оролцсон 168 шүүх хуралдааны нарийн бичгийн даргын 70 хувь нь буюу 118 нь чимэгэ бичээч системийг ашиглаж үзээгүй байх бөгөөд Чимэгэ системийг ашиглаж байсан болон ашиглаж байгаа 50 шүүх хуралдааны нарийн бичгийн даргын 25 нь системийг ашиглахад дараах хүндрэл, бэрхшээл тулгарсан гэж хариулжээ. Үүнд:

- ✓ Зарим бүдэг хэлсэн үнийг хөрвүүлдэггүй буруу хөрвүүлдэг үсгийн фонд зөрдөг. Жишээ нь: Ө, ү үсгийг е, у үсгээр сольж бичдэг.
- ✓ Заримдаа гацах тохиолдол гардаг.
- ✓ Утга, найруулгын алдаа гардаг.
- ✓ Хажууд буй хүний яриа давхар бичигддэг.
- ✓ Үргэлжилсэн үгийн зохиол шиг хөрвүүлэгддэг учраас цэг, таслал найруулга зүй оруулахад хүндрэлтэй байдаг.
- ✓ Тайлбар хэлж буй оролцогч сул үг их хэлсэн бол тайлбарыг нь засахад төвөгтэй. Мөн он, сар, өдөр тоогоор биш үсгээр бичигддэг. Эрүүгийн хуулийн зүйл анги мөн тоогоор биш бичгээр бичигддэг. Мөн маш замбараагүй ойлгомжгүй ярьсан оролцогчийн тайлбарыг дахин сонсож бичих шаардлага үүсдэг.
- ✓ Хэргийн оролцогчдын дуу хоолойг ялгах боломжгүй учраас хэлсэн үг бүрийг үргэлжилсэн үгээр бичдэг.
- ✓ Хөрвүүлсэн текстийг найруулж бичих шаардлага үүсдэг.
- ✓ Системд интернэтийн хурд нөлөөлдөг.

Мөн Ажлын хэсгийн зарим гишүүд Нийслэлийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх болон Баянзүрх дүүргийн иргэний хэргийн шүүхийн шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нартай ярилцахад “компьютерын хүчин чадал муу, хуучин байгаатай холбоотойгоор үгийн алдаа засдаг Болор үг, үсгийн алдаа шалгагч системийг ашиглахад гацалт үүсдэг, мөн Чимэгэ системийг ашиглан хөрвүүлэхэд удаан уншдаг” гэж хариулсан.

⁴ Шүүгчийн хүний нөөцийн газар

⁵ Захиргаа, удирдлагын газар

⁶ Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 193 дугаар тогтоол



Нийт оролцогч 168 шүүх хуралдааны нарийн бичгийн даргаас асуусан “Чимэгэ системийг шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөхөд хэр боломжийн гэж үзэж байна вэ” гэсэн төсөөллийн асуулгад 36.3 хувь нь боломжийн гэж, 20.2 хувь нь зарим талаараа боломжийн, 20.2 хувь боломжгүй гэсэн бол 23.2 хувь нь хэлж мэдэхгүй гэж хариулсан байна.

Иймд судалгаа №02, 03-ын мэдээлэлд үндэслэн дараах дүгнэлтэд хүрч байна:

1. Анхан болон давж заалдах шатны шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нар Чимэгэ системийг хэрэглэхэд компьютерын хүчин чадал, интернэтийн хурд нөлөөлсөн байна.

2. Чимэгэ бичээч системийг анхан болон давж заалдах шатны шүүхэд туршилтаар хугацаа зааж хэрэглүүлэх. Хэрэглэхээс өмнө сургалт орох. Суурь түвшинг тодорхойлох. 1 минутад бичих дундаж хувийг тогтоох, ур чадварыг тодорхойлох.

3. Чимэгэ бичээч системийг туршилтаар хэрэглэсний дараа шүүх хуралдааны тэмдэглэл хуулийн хугацаанд албажсан тоог суурь түвшинтэй харьцуулан дүгнэх.

4. Чимэгэ бичээч системийг хэрэглэх бол шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарын одоо хэрэглэж байгаа компьютерын хүчин чадлыг сайжруулж, иж бүрэн шинээр солих.

5. Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарыг албан ёсны эрхтэй Microsoft word программаар хангах.

6. Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарын компьютерыг иж бүрэн сольж, албан ёсны эрхтэй Microsoft word программаар хангасны дараа “Болор” алдаа шалгагчийг бүх нарийн бичгийн даргын компьютерт суулгах.

7. Чимэгэ системийг нэвтрүүлэх тохиолдолд шүүхийн онцлогт тохируулан хүний дуу таних, нутгийн аялга таних, мэргэжлийн үг, тодорхойлолт, хуулийн зүйл, хэсгийг автоматаар гаргах таних сайжруулалтыг нэмж хийлгэх.

Дээрх нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд анхан болон давж заалдах шатны шүүхэд Чимэгэ системийг ашиглахад шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарын компьютер, тоног төхөөрөмжийн хүчин чадал муу, интернэтийн хурд тааруу байх тул суурь нөхцөлийг хангах шаардлагатай байна.

Энэхүү компьютер, тоног төхөөрөмжийн хүчин чадал муу, интернэтийн хурд тааруу байгаа байдлыг засахгүйгээр Чимэгэ системийг нэвтрүүлэх нь шүүх хуралдааны тэмдэглэл хуулийн хугацаанд албажих, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын ажлын ачааллыг хөнгөвчлөх эерэг үр дүнд хүрэхэд сөргөөр нөлөөлж, ахиц гарахааргүй байна.

--oOo--



ХАВСРАЛТ

Хавсралт 1. Ажлын 5 хоногт оролцож байгаа шүүх хуралдааны дундаж тоог хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрлөөр харуулав.

		7. Ажлын 5 хоногт оролцож байгаа шүүх хуралдааны дундаж тоо:									
		20 болон түүнээс дээш ачааллаас хамаарч	20-оос дээш	25	30	A. 5 хүртэл	B. 6-10	C. 11-ээс 15 хүртэл	D. 16-аас дээш	Дундаж тоо 20-с дээш	Total
4. Та дараах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрлөөс аль төрөл дээр ажилладаг вэ?	Захиргаа	-	-	-	-	1	12	9	1	-	23
	Захиргаа, Зөрчил	-	-	-	-	-	-	-	1	-	1
	Иргэн	1	-	1	1	1	6	22	26	1	59
	Эрүү	-	1	-	-	-	1	12	19	-	33
	Эрүү, Захиргаа, Зөрчил	-	-	-	-	-	-	-	1	-	1
	Эрүү, Зөрчил	-	-	-	-	-	1	2	2	-	5
	Эрүү, Иргэн	-	-	-	-	-	1	2	2	-	5
	Эрүү, Иргэн, Захиргаа	-	-	-	-	1	1	1	-	-	3
	Эрүү, Иргэн, Захиргаа, Зөрчил	-	-	-	-	-	5	8	11	-	24
	Эрүү, Иргэн, Зөрчил	-	-	-	-	1	7	4	2	-	14
Total		1	1	1	1	4	34	60	65	1	168

Хавсралт 2.

Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга
нараас авах асуумж

**Чимэгэ бичээс системийг нэвтрүүлэхийн өмнөх
нөхцөл байдлыг тодорхойлох судалгаа**

Судалгааны зорилго: Энэхүү судалгаа нь шүүх хуралдааны нарийн бичиг нарийн чадварыг үнэлэх бус харин шүүх хуралдааны тэмдэглэлд хэр их хугацаа зарцуулдаг, ямар хүндрэл үүсдэг болохыг тогтоох, “Чимэгэ бичээч систем”-ийн давуу болон сул тал зэргийг судална.

1. Таны ажиллаж байгаа шүүхийн байршил:

- A. Нийслэл
- B. Аймаг



- С. Сум дахь сум дундын шүүх
2. Таны нас:
 А. 30 хүртэл b) 31-40 c) 41-50 d) 51-60 e) 61-дээш
3. Аль шатны шүүхэд ажилладаг вэ?
 В. Анхан b.Давах
4. Та дараах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрлөөс аль төрөл дээр ажилладаг вэ?
 a.Эрүү b.Иргэн c.Захиргаа
5. Шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалд ажилласан хугацаа:
 А. 6 сар хүртэл
 В. 1 жил хүртэл
 С. 1-ээс 2 жил
 D. 2-4 жил
 E. 5 дээш жил
6. Таны 1 минутад бичих тэмдэгтийн хурд хэд вэ?
 А. 100 тэмдэгт хүртэл
 В. 200 тэмдэгт хүртэл
 С. 300 тэмдэгт хүртэл
 D. 400 тэмдэгт хүртэл
 E. 400 тэмдэгтээс дээш
7. Ажлын 5 хоногт оролцож байгаа хурлын дундаж тоо:
 А. 5 хүртэл
 В. 6-10
 С. 11-ээс 15 хүртэл
 D. 16-аас дээш
 E. Бусад.....
8. Өдөрт оролцож байгаа шүүх хуралдааны дундаж хугацаа:
 А. 1 цаг хүртэл
 В. 1-ээс 2 цаг
 С. 3-аас 4 цаг
 D. 5-аас 8 цаг
 E. 8 цагаас дээш
9. 1 цаг үргэлжилсэн шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөхөд (шүүгчид хянуулах хүртэлх) зарцуулж буй хугацаа: /Чимэгэ бичээч системийг ашиглахгүйгээр хөрвүүлэх хугацааг тооцоолж бичнэ үү/

Боломжууд	30 минут хүртэл	30-аас 1 цаг хүртэл	1-ээс 2 цаг хүртэл	2-оос 3 цаг хүртэл	4-өөс дээш цаг
Хурлаас тэмдэглэлийг бүрэн бичдэг	90	28	26	8	9
Хурлаас тэмдэглэлийг 60-80 хувийг бичдэг					
Хурлаас тэмдэглэлийг 40-60 хувийг бичдэг					
Хурлаас тэмдэглэлийг 30 хүртэл хувийг бичдэг					



Тэмдэглэлийг хурлын үеэр бичихгүй					
-----------------------------------	--	--	--	--	--

10. Авиаг бичвэр болгон хувиргадаг “Чимэгэ бичээч систем”-ийг ашиглаж байсан уу?

- Тийм
- Үгүй /27-р асуулт руу үсэрнэ/

11. Тийм бол ашиглахад ямар нэгэн “Чимэгэ бичээч систем”-тэй холбоотой асуудал гарч байсан уу?

- Тийм
- Үгүй

12. Чимэгэ бичээч системийн аль хувилбарыг ашиглаж байсан бэ?

- Шүүхэд туршигдсан өмнөх хувилбар (2020-2022 он)
- Шинэчлэгдсэн хувилбар (2023 оны 05 сар)
- Хэлж мэдэхгүй байна

13. Та чимэгэ бичээч системийг хэр удаан ашиглаж байна вэ?

- 1 сараас доош
- 1-3 сар
- 3-6 сар
- 1 жил ба түүнээс дээш

14. Чимэгэ бичээч систем систем”-ийг хэр давтамжтай ашигладаг вэ?

- Шаардлагатай тохиолдолд
- Хааяа
- Байнга

15. Чимэгэ бичээч систем нь дараах боломжуудтай бөгөөд ашиглах явцад эдгээр боломжуудад асуудал гарч байсан эсэхийг үнэлнэ үү.

Боломжууд	Маш боломжийн	Боломжийн	Заримдаа асуудал үүсдэг	Боломжгүй	Огт боломжгүй	Ашиглах шаардлага гардаггүй
Веб апп болон мобайл апп хувилбартай						
Зөвшөөрөгдөх формат: MP3, MP4, Wav, M4a форматаас						
Таны хөрвүүлэх бичлэгийн урт худалдаж авсан цагаас хэтрэхгүй байх ёстой бөгөөд 1 удаа оруулах файлын дээд хэмжээ 8 цаг (10GB) байна						
Хөрвүүлсэн бичвэрээ шалгаж засварлах						
Бичвэр дундаас үг хайна.						
Сул үг ялгах функцтэй.						
Монгол хэлний алдаа шалгах “Болорспелл” программтай холбогдсон						

16.1 цаг үргэлжилсэн шүүх хуралдааны тэмдэглэлийг “Чимэгэ бичээч систем” систем ашиглан хөрвүүлэхэд хэдэн минут зарцуулдаг вэ?

.....

17. “Чимэгэ бичээч систем” системээр хөрвүүлсэн 1 цагийн шүүх хуралдааны тэмдэглэлийн агуулга, найруулга засах, хэлбэрт оруулахад зарцуулдаг хугацаа:



.....

18. “Чимэгэ бичээч систем” систем систем ашигласнаар шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөх ажилд үзүүлсэн нөлөөлөл

- А.Сайнаар нөлөөлсөн
- Б.Сөргөөр нөлөөлсөн /23-р асуулт руу үсэрнэ/
- В.Нөлөөлөл үзүүлээгүй /24-р асуулт руу үсэрнэ/

19. “Чимэгэ бичээч систем” систем ашиглан шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөхөд гарсан эерэг нөлөөлөл

- А.Хугацаа хэмнэсэн
- Б.Хурдан шивэх чадвар шаардлагагүй болсон
- В.Ачаалал багассан
- Г.Бусад /нөхөж бичих/

20. “Чимэгэ бичээч систем” систем ашиглан шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөхөд гарсан сөрөг нөлөөлөл

- А.Хугацаа хэмнээгүй
- Б.Шат дамжлага, ачаалал нэмсэн
- В.Бусад ур чадвар шаардлагатай болсон
- Г.Бусад /нөхөж бичих/

21. “Чимэгэ бичээч систем” систем ашиглан шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөхөд нөлөөлөл үзүүлээгүй

- А.Зарцуулах хугацаа адил
- Б.Ачаалал өөрчлөгдөөгүй
- В.Шүүх хуралдаанд зүгээр суусан
- Г.Бусад /нөхөж бичих/

22. “Чимэгэ бичээч системийн талаарх дараах бодомжийг харгалзуулна уу.

Чимэгэ бичээч систем ...	Тийм	Үгүй	Хэлж мэдэхгүй байна
...ашиглахад компьютерын хүчин чадал хамааралтай эсэх			
...ашиглахад интернэтийн хурд нөлөөлдөг эсэх			
... ашиглан шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөхөд гарсан хүндрэл байгаа эсэх			

23. Хэрэв хүндэр гарч байсан бол гарсан хүндрэлийн талаар тодорхой бичнэ үү.

.....

.....

.....



24. “Чимэгэ бичээч систем”-ийг шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөх зэрэгт ашиглахад боломжтой эсэх:

- A. Маш боломжийн b. боломжийн c. Зарим талаараа d. Боломжгүй e. Огт боломжгүй f. Хэлж мэдэхгүй байна

25. Хэрэв боломжгүй, огт боломжгүй гэж хариулсан бол шалтгаанаа бичнэ үү:

Яагаад гэвэл

Хавсралт 3.

Чимэгэ бичээс системийг нэвтрүүлэхийн өмнөх нөхцөл байдлыг тодорхойлох судалгаа

Судалгааны зорилго: Энэхүү судалгаа нь шүүх хуралдааны нарийн бичиг нарийн чадварыг үнэлэх бус харин шүүх хуралдааны тэмдэглэлийг хуульд заасан хугацаанд албаждаг эсэх шалтгаан нөхцөлийг тодруулах зорилготой юм.

1. Таны ажиллаж байгаа шүүхийн байршил:
D. Нийслэл
E. Аймаг
F. Сум дахь сум дундын шүүх
2. Аль шатны шүүхэд ажилладаг вэ?
C. Анхан b. Давах
3. Та дараах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрлөөс аль төрөл дээр ажилладаг вэ?
a. Эрүү b. Иргэн c. Захиргаа
4. Шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалд ажилласан хугацаа:
F. 6 сар хүртэл
G. 1 жил хүртэл
H. 1-ээс 2 жил
I. 2-4 жил
J. 5 дээш жил
5. Шүүх хуралдааны нарийн бичгийн даргын туршлага, ур чадвар болон өөрөөс үл хамаарах шалтгаанаар шүүх хуралдааны тэмдэглэлийг хуульд заасан хугацаа хэтрүүлж албажуулах тохиолдол байдаг уу?
A. үргэлж /90-100%/ B. байнга /70-89%/ В. ихэвчлэн /50-69%/
Г. Заримдаа /30-49%/ Д. хааяа /0-29%/ Д. огт үгүй
6. Шүүх хуралдааны тэмдэглэлийг хуульд заасан хугацааг хэтрүүлж албажуулж буй шалтгаан нөхцөлийг дугуйлна уу. /Хамгийн их нөлөөлж буй гэж үзсэн 3 хүртэлх хариултыг дугуйлна/
A. Өдөрт олон шүүх хуралдаанд дараалж ордог
B. Шүүгч ажлын эхний өдрүүдэд шүүх хуралдааныг шахаж товлодог
B. Шүүх хуралдаан дууссаны дараа боловсруулалт хийх хугацаа бага байдаг
Г. Шүүгч тэмдэглэлийг хянаж, албажуулахад хугацаа их ордог



Д.Удирдах албан тушаалтнаас өгсөн бусад үүрэг даалгавар их байдаг

Е. Хэргийн оролцогч нарын маргаж буй асуудал, шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж буй нарийн мэргэжлийн үг, хэллэгийг ойлгохгүй байсны улмаас бичлэгийг дахин дахин олон удаа сонсох, хэргийн материалаас холбогдох мэдээллийг цуглуулж, тодруулах ажиллагаа хугацаа шаарддаг

Ё.Компьютерын хурд, гацалт нөлөөлдөг

Ж.Туршлага дутдаг

З. Ур чадвар нөлөөлдөг

И. Хувь хүний ажлын зохион байгуулалт нөлөөлдөг

7. Дээрх шалтгаан нөхцөлүүдээс гадна өөр шалтгаан нөхцөл байгаа бол холбогдох тайлбар үндэслэлийг бичнэ үү.

.....
.....
.....
.....

8. Та өөрийн найруулга зүй хийх ур чадвараа хэрхэн үнэлж байна вэ?

А. Маш сайн Б.Сайн В.Хэвийн Г.Дунд Д.Дунджаас доогуур

9. Та өөрийн хурдан шивэх чадварыг хэрхэн үнэлж байна вэ?

А. Маш сайн /400-500 тэмдэгт/ Б.Сайн /300-400 тэмдэгт/
В.Хэвийн /200-300 тэмдэгт/ Г.Дунд /100-200 тэмдэгт/
Д.Дунджаас доогуур /100 хүртэлх тэмдэгт/

Анхан болон давж заалдах шатны шүүхийн тамгын газрын дарга болон холбогдох албан хаагчдаас авах асуумж

1.Шүүх хуралдааны нарийн бичгийн даргын туршлага, ур чадвар болон өөрөөс үл хамаарах шалтгаанаар шүүх хуралдааны тэмдэглэлийг хуульд заасан хугацаа хэтрүүлж албажуулах тохиолдол байдаг уу?

А. үргэлж /90-100%/ Б.байнга /70-89%/ В.ихэвчлэн /50-69%/
Г. Заримдаа /30-49%/ Д.хааяа /0-29%/ Д.огт үгүй

2. Шүүх хуралдааны тэмдэглэлийг хуульд заасан хугацааг хэтрүүлж албажуулж буй шалтгаан нөхцөлийг дугуйлна уу. /Хамгийн их нөлөөлж буй гэж үзсэн 3 хүртэлх хариултыг дугуйлна/

А.Өдөрт олон шүүх хуралдаанд дараалж ордог
Б.Шүүгч ажлын эхний өдрүүдэд шүүх хуралдааныг шахаж товлодог
В.Шүүх хуралдаан дууссаны дараа боловсруулалт хийх хугацаа бага байдаг
Г.Шүүгч тэмдэглэлийг хянаж, албажуулахад хугацаа их ордог
Д.Удирдах албан тушаалтнаас өгсөн бусад үүрэг даалгавар их байдаг



Е. Хэргийн оролцогч нарын маргаж буй асуудал, шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж буй нарийн мэргэжлийн үг, хэллэгийг ойлгохгүй байсны улмаас бичлэгийг дахин дахин олон удаа сонсох, хэргийн материалаас холбогдох мэдээллийг цуглуулж, тодруулах ажиллагаа хугацаа шаарддаг

Ё.Компьютерын хурд, гацалт нөлөөлдөг

Ж.Туршлага дутдаг

З. Ур чадвар нөлөөлдөг

И. Хувь хүний ажлын зохион байгуулалт нөлөөлдөг

3.Дээрх шалтгаан нөхцөлүүдээс гадна өөр шалтгаан нөхцөл байгаа бол холбогдох тайлбар үндэслэлийг бичнэ үү.

.....
.....
.....
.....

4.ШХНБД нарын найруулга зүй хийх ур чадвар болон шивэх хурд зэргийг үнэлнэ үү.

	Маш сайн	Сайн	Хэвийн	Муу	Маш муу
Найруулга зүй					
Шивэлтийн хурд					
Ажлын зохион байгуулалт					

--oOo--